MNAS P 403

МОНГОЛЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БАТЛАВ:
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....С.СОРОНЗОНБОЛД

ШУДАРГА БАЙДЛЫН ЖУРАМ

Боловсруулсан:	Хянасан:
Д.Удвал	Д.Алтангэрэл

Энхтайвны өргөн чөлөө 46А
Улаанбаатар 211051, Монгол Улс
Утас: (976) 51 263907, (976) 51 263689
Fax: (976) 11 458032
Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 22.06.2010

ӨӨРЧЛӨЛТ NO: 01
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 20.01.2021

ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУДАС

№	Өөрч. No	Хуудас. No	ӨӨРЧЛӨЛТИЙН ШАЛТГААН
1	1	Бүх	Үндэсний Итгэмжлэлийн Төв болж шинэчлэгдэн зохион байгуулагдсантай холбогдуулан мэдээлэл шинэчлэв.
2			
3			
4			

АГУУЛГА

Бүлэг	Гарчиг	Хуудас №.
1	Зорилго ба хамрах хүрээ.....	4
2	Тодорхойлолт ба товчлол.....	4
3	Ерөнхий зүйл.....	5
4	Хариуцлага.....	5
5	Журам.....	5
6	Шударга байдлыг хамгаалах.....	9
7	Мониторинг хийх үйл ажиллагаа.....	10
8	Бүртгэл.....	10

Шударга байдлын журам

MNAS P403

1 Зорилго ба хамрах хүрээ

Энэхүү журмын зорилго нь MNAS-ийн үйл ажиллагааны бодиттой, шударга байх байдлыг хамгаалахад шаардагдах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Энэхүү баримт бичгийг MNAS-ийн үйл ажиллагаанд болон бүх ажилтнууд, үнэлгээний мэргэжилтэн, техникийн шинжээч, холбогдох байгууллага, сонирхогч талууд ашиглах боломжтой.

2 Тодорхойлолт ба товчлол

2.1 Тодорхойлолт

2.1.1
Шударга байдал гэдэг нь бодитой байхыг хэлнэ.

2.1.2
Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь тухайн хүний хувийн ашиг сонирхлын болон мэргэжлийн ашиг сонирхлын болон нийтийн ашиг сонирхлын хоорондох зөрчил үүсэх магадлалтай тул тухайн хүний шударга байдлыг алдагдуулах нөхцөл байдлыг хэлнэ.

2.1.3
Бие даасан байдал гэдэг нь бусдын хяналт, нөлөөлөл, дэмжлэг, туслалцаа авах гэх мэтээс тусдаа байхыг хэлнэ.

2.1.4
Сонирхогч талууд гэдэгт итгэмжлэлд шууд болон шууд бусаар нөлөөлөх ашиг сонирхол бүхий хувь хүн, байгууллага байх бөгөөд үүнд тохирлын үнэлгээний байгууллага, тэдгээрийн холбоо, үйлчлүүлэгчид, үйлдвэр үйлчилгээ, худалдааны холбоо, схем эзэмшигч, засгийн газрын зохицуулагч байгууллага эсвэл бусад төрийн үйлчилгээ, төрийн бус байгууллага болон хэрэглэгчийн байгууллагууд багтана.

2.1.5
Бодит байдал гэдэг нь ашиг сонирхлын зөрчилгүй эсвэл MNAS-ийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байхыг хэлнэ.

2.1.6
Ил тод байдал нь нээлттэй байдал, харилцаа холбоо, хариуцлагатай байдлыг илэрхийлдэг. Энэ нь бусдад ямар үйл ажиллагаа хэрэгжүүлдэгийг харахад хялбар байна гэсэн үг.

2.1.7
Хамаарал бүхий байгууллага нь MNAS-тай нийтийн өмчлөл эсвэл гэрээгээр холбогдсон тусдаа хуулийн этгээд байна. MNAS-ийн аливаа бүтэц, зохион байгуулалт нь хамаарал бүхий байгууллагуудтай холбоотой эсэхийг гэж авч үзнэ.

2.2 Товчлол

- MNAS – Монголын итгэмжлэлийн тогтолцоо

- FOC – Тохиолдох давтамж
- IAF – Олон улсын итгэмжлэлийн форум
- ILAC – Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага
- SOI – Аюулын нөлөө

3 Ерөнхий зүйл

3.1 Шударга байдал нь MNAS-ийн үндсэн үнэт зүйлсийн нэг бөгөөд аливаа итгэмжлэлийн ажил, үйлчилгээний үндэс болдог.

3.2 MNAS нь ажил, үйлчилгээгээ явуулахад шударга байхын ач холбогдлыг ойлгох бөгөөд үзүүлж буй итгэмжлэлийн үйлчилгээний бодит, шударга байдлыг хамгаалах үүднээс ашиг сонирхлын зөрчлийг зохицуулна.

3.3 ISO/IEC 17011:2017 *"Тохирлын үнэлгээ-Тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжилдэг итгэмжлэлийн байгууллагад тавих шаардлага"* стандартад заасан шударга байдлын шаардлагыг MNAS баримтална.

3.4 MNAS нь итгэмжлэлийн ажил, үйлчилгээ үзүүлэхэд баримталж буй шударга байдлыг хамгаалах үүрэг хариуцлагыг илэрхийлсэн Дээд удирдлагын шударга ёсны бодлогын мэдэгдлийг баримтжуулсан байна. Шударга ёсны бодлогын мэдэгдлийг Итгэмжлэлийн байгууллагын https://mnas.gov.mn/ цахим хуудсанд байршуулна.

4 Хариуцлага

4.1 MNAS-ийн бүх ажилтнууд, үнэлгээний мэргэжилтнүүд/техникийн шинжээчид болон бусад бүх хороод нь шударга байдалд нөлөөлж болзошгүй арилжааны, санхүүгийн болон бусад шахалтаас ангид байх ёстой.

4.2 Шударга байдлын эрсдэлийг тодорхойлох ажлын хэсгийг жил бүр Итгэмжлэлийн байгууллагын дарга томилно. Ажлын хэсэг нь MNAS-ийн эрсдэлийн жагсаалтад бүртгэгдсэн янз бүрийн үйл явц, шударга байдлын эрсдэлийг тодорхойлох үүрэгтэй. Үүнийг жил бүр удирдлагын дүн шинжилгээгээр авч хэлэлцэнэ.

4.3 Эрсдэлийн менежмент нь сайн засаглалын чухал элемент учраас MNAS-ийн дээд удирдлага нь итгэмжлэлийн эрсдэлийн менежментийн бодлогын хэрэгжилт, эрсдэлийн хяналтын арга хэмжээг багтаасан MNAS-ийн эрсдэлд хяналт тавина. MNAS-ийн Дээд удирдлага нь жилд хамгийн багадаа нэг удаа хяналтыг гүйцэтгэнэ.

5 Журам

5.1 MNAS нь хамаарал бүхий хувь хүн, байгууллага, холбогдох хүнтэй харилцах харилцаанаас үүссэн ашиг сонирхлын зөрчлийн боломжуудыг хүлээн зөвшөөрнө. Эрсдэл нь MNAS-ийн үйл ажиллагаа, харилцаа холбоо, түүний ажилтнуудын харилцаанаас үүснэ. Тиймээс эрсдэлийн эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Итгэмжлэх үйл явцад оролцогч MNAS-ийн бүх ажилтнууд;

- Үнэлгээний мэргэжилтэн/ Техникийн шинжээчид;

- Итгэмжлэлийн техникийн хорооны гишүүд.

5.2 Эрсдлийн үнэлгээ нь сонирхогч талуудын дараах байдлаар явагдаж буй үйл явц юм. Үүнд:

- MNAS-ийн даргын удирдлагын дүн шинжилгээ;

- Санхүүгийн эрсдэл ба аудитын дүн шинжилгээ;

- MNAS-ийн захиргаа удирдлагын нэгжийн дотоод аудит; ба

- MNAS-ийн сонирхогч талуудын оролцоо.

5.3 Эрсдэлийн олон ангилал байдаг бөгөөд MNAS нь дараах ангиллын эрсдлүүдийг авч үзэж, аюулыг тодорхойлсон болно. Үүнд:

5.4.1 Стратегийн эрсдэл

- Нэр хүндийн эрсдэл:
  Олон улсын болон үндэсний нэр хүндээ алдахтай холбоотой аюул.

- Менежментийн өөрчлөлтийн эрсдэл:
  MNAS нь шинэчлэгдсэн/шинэ итгэмжлэлийн гол стандартын шилжилтийг амжилттай хийж чадаагүй тохиолдолд гарч болзошгүй аюул.

5.4.2 Үйл ажиллагааны эрсдэл

- Шударга байдлын эрсдэл, тухайлбал:

  - Хувийн ашиг сонирхлын аюул заналхийлэл:
    Өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг хүн, байгууллагаас үүсдэг;

  - Субьектив аюул заналхийлэл:
    Хувь хүний үзэл бодол нь бодит нотолгооноос хэтрэх үед үүсдэг;

  - Танил талуудын аюул:
    Тухайн хүнийг таньдаг эсвэл итгэдэг хүнээс үүсдэг. Жишээ нь: өргөдөл гаргагч /итгэмжлэгдсэн байгууллага эсвэл дадлагажигч үнэлгээний мэргэжилтэнтэй харилцаа тогтоож, тухайн объектыг үнэлэхэд нөлөөлөх үнэлгээний мэргэжилтэн эсвэл ажилтнууд;

  - Айлган сүрдүүлэх аюул:
    Хувь хүн /байгууллага/ сонирхогч этгээдээс айх айдсаас болж шударга үйлдэл хийхээс сэргийлэх;

- Санхүүгийн аюул:
  MNAS /түүний ажилтнууд/ үнэлгээний мэргэжилтнүүдийн орлогын эх үүсвэр гэх мэт.

– Итгэмжлэлийн үйлчилгээний зорилтыг биелүүлж чадаагүй аюул:
MNAS нь үйл ажиллагааны зорилгоо биелүүлж чадаагүй тохиолдолд гарч болзошгүй
аюул.

5.4.3 Хүний нөөцийн эрсдэл

– Хангалттай чадварлаг боловсон хүчин:
Цөөн ажилтантай байх, чадваргүй боловсон хүчин сонгосноос үүдсэн аюул;

– Хангалттай, чадвартай үнэлгээний мэргэжилтэн:
Хүлээгдэж буй хэрэгцээ шаардлагыг ханган биелүүлэх чадавхитай үнэлгээний мэргэжилтэний нөөц хангалтгүй байснаас үүсэх аюул;

– Чадварлаг менежмент:
Ур чадварыг тогтоох/ хадгалах залгамж халаагаа төлөвлөөгүйгээс үүсэх аюул.

5.5 Үйл явцын эрсдэлийг үнэлэх

5.5.1 MNAS-ийн итгэмжлэлийн үйл ажиллагаа нь болзошгүй аюул заналхийллээс болж хохирч болохгүй. Үүний илрэлийн бодит давтамж, нөлөөллийн ноцтой байдлыг үнэлэх замаар тодорхойлж болно. Үүнд:

a) MNAS нь эрсдлийг үнэлж, эрэмбэлнэ.

b) MNAS нь ийм аюулыг хэрхэн арилгах, багасгах арга хэмжээний түвшинг тодорхойлж, эрсдэлийг тодорхойлно.

c) Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлж, итгэмжлэл олгох эсэхийг MNAS тодорхойлно.

5.5.2 Шалгуур

Дараах шалгуурыг харгалзан үзнэ.

– Тохиолдолын давтамж (FOC)

- Жилд дор хаяж нэг удаа тохиолддог зүйлийг 3 оноогоор “Өндөр” гэж үнэлнэ.
- 5 жилд нэг удаа тохиолддог зүйлийг 2 оноогоор “Дунд зэрэг” гэж үнэлнэ.
- 10 жилд нэг удаа тохиолддог зүйлийг 1 оноогоор “Бага эрсдэлтэй” гэж үнэлнэ.

– Нөлөөллийн ноцтой байдал (SOI)

- “Өндөр” нөлөөлөлтэй үр дүнг 3 гэж авна.

- “Дунд зэргийн” нөлөөлөлтэй үр дүнг 2 гэж авна.
- “Бага нөлөөлөлтэй” үр дүнг 1 гэж авна.

5.5.3 Эрсдэлийн хэмжигдэхүүн

Эрсдлийн хэмжигдэхүүнийг FOC оноог SOI оноогоор үржүүлж тооцно.

Нөлөөллийн ноцтой байдал (SOI)		Тохиолдлын давтамж (FOS)		
	Оноо	3	2	1
	3	9	6	3
	2	6	4	2
	1	3	2	1

Эрсдэлийн ангилал

• Өндөр эрсдэлтэй	Тохиолдлын давтамж өндөр
	Нөлөө их
	Эрсдэлийн хэмжигдэхүүн= 6-аас 9
• Эрсдэлтэй	Тохиолдлын давтамж өндөр/дунд
	Нөлөө дунд зэрэг эсвэл давтамж бага боловч нөлөө ихтэй.
	Эрсдэлийн хэмжигдэхүүн = 3 –аас 4
• Бага эрсдэлтэй	Тохиолдлын давтамж бага
	Нөлөө бага
	Эрсдэлийн хэмжигдэхүүн = 1-ээс 2

5.5.5 Эрсдэлтэй харьцах

Эрсдлийн зохих хандлагыг судлан шинжилж, хэмжсэний дараа дор дурьдсан дагуу хийнэ:

– **Өндөр эрсдэлтэй**
- Эрдэлийг нэн түрүүнд бууруулах арга хэмжээ авах;

– **Significant**
- Эрдэлийг бууруулах арга хэмжээ авах, хяналт мониторинг хийх, мэдээлэх;

– **Insignificant**
- Эрсдэлгүй байх боломжтой.

6 Шударга байдлыг хамгаалах

6.1 MNAS-ийн бодлого ба журам

6.1.1 MNAS нь бодлого, журмыг боловсруулж, шударга байдлыг хангаж ажиллана. MNAS-ийн Дээд удирдлага нь үнэт зүйлсийг бодлогод тусгах, журамд нийцүүлэн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажиллахыг баталгаажуулна.

6.2 MNAS-ийн ажил, үйлчилгээ

6.2.1 MNAS нь итгэмжлэлийн ажил, үйлчилгээ болон итгэмжлэлтэй холбоотой асуудлаар сургалт явуулна.

6.2.2 MNAS-д итгэмжлүүлэхээр сайн дурааараа өргөдөл гаргасан тохирлын үнэлгээний байгууллага нь холбогдох хууль тогтоомж, MNAS-ийн итгэмжлэлийн шаардлагыг хангасан аливаа байгууллагын хэмжээ, харьяалал, санхүүгийн байдлаас үл хамааран итгэмжлэл авах боломжтой.

6.2.3 MNAS-ийн итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын тооноос хамаарахгүй. Өргөдөл гаргагч болон MNAS-ийн хоорондох ашиг сонирхлын зөрчлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах, нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, итгэмжлэлийн шаардлагыг санаатай зөрчсөн тохиолдолд итгэмжлэлийг олгохгүй байна.

6.2.4 Сургалт, чиг баримжаа олгох эсвэл боловсролын сургалтанд багшаар оролцох ба эдгээр сургалтууд нь нийтийг хамарсан ерөнхий мэдээллээр хангах байдлаар хязгаарлагддана. Тухайн тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой шийдэл гаргахгүй. Үнэлгээний явцад үнэ цэнийг нэмэх зорилгоор үнэлгээний явцад тодорхой сайжруулах боломжийг тодорхойлсон зөвлөмж өгч болно. Итгэмжлэлийн шаардлага, түүний дотор тохирлын үнэлгээний стандартын шаардлагыг багтаасан схем эзэмшигчдэд зөвлөгөө өгч болно.

6.2.5 MNAS нь нийтийн өмч буюу гэрээний зохицуулалтаар бусад хуулийн этгээдтэй хамтран ажиллах шаардлагатай бол сонирхсон этгээдийн үйл ажиллагаа, итгэмжлэлийн нууцлал, шударга байдлыг алдагдуулахгүй байхыг шаардана.

6.3 Зөвлөгөө өгөх

6.3.1 MNAS нь итгэмжлэлийн ажил, үйлчилгээ үзүүлэх аливаа байгууллагад зөвлөгөө өгөхгүй.

6.3.2 MNAS нь тохирлын үнэлгээний байгууллагуудын гүйцэтгэдэг тохирлын үнэлгээний үйлчилгээг санал болгохгүй.

6.3.3 Тухайн байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн шинжээчийг зөвлөх үйлчилгээг зогссоны дараа 2 жилийн хугацаанд шинжээчээр болон итгэмжлэлийн техникийн хорооны гишүүнээр ажиллаж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулахгүй.

6.3.4 Өгсөн мэдээлэл нь ерөнхий бөгөөд тусгай, захиалгат зөвлөхийн үйл ажиллагаа, үйлчилгээ агуулаагүй бол дараах зүйлийг зөвлөх үйлчилгээ гэж үзэхгүй. Үүнд:

- Шинжээчийн зөвлөгөө;
- Өргөдөл гаргагч тохирлын үнэлгээний байгууллагуудад зориулсан ерөнхий арга хэрэгсэл, удирдамж өгөх;
- MNAS-ийн сургалт, семинар;
- Итгэмжлэлийн стандарт /удирдамж/ шаардлагыг тайлбарлахтай холбоотой мэдээллийг хуваалцах;
- Мэдээлэл цуглуулах, баримт бичиг, дүгнэлтийг хэлэлцэх, анхдагч үнэлгээ хийхэд бэлэн байдлыг шалгах урьдчилсан үнэлгээ;
- Итгэмжлэлийн үнэлгээний явцад үнэ цэнийг нэмэх зорилгоор тодорхой шийдлийг

санал болгохгүйгээр сайжруулах боломжийг тодорхойлох;
- Байгууллагад MNAS-ийн итгэмжлэлийг авах, хадгалах талаар тодорхой зөвлөгөө өгөх байдлаар оролцдоггүй бусад аливаа үйл ажиллагаа.

6.5 MNAS-ийн ажилтан

6.5.1 MNAS-ийн ажилтнууд засгийн газрын байгууллагын ажилтан байна. MNAS-ын ажилтнууд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу итгэмжлэлийн үйл явцад нөлөөлөх арилжааны, санхүүгийн, улс төрийн болон бусад дарамт шахалт болон бусад ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх шаардлагатай.

6.6 Үнэлгээний мэргэжилтэн/ Техникийн шинжээчид

6.6.1 MNAS-ийн үнэлгээний мэргэжилтэн/техникийн шинжээчид нь шударга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар MNAS-тай гэрээ байгуулна. Үнэлгээний багийг сонгохдоо үнэлгээний тэргүүлэх мэргэжилтэн нь багийн гишүүн бүрийн шударга, үл ялгаварлахаас өөр бусад үйлдэл хийхэд хүргэж болзошгүй ашиг сонирхолоос ангид байлгах үүрэгтэй. Үнэлгээ хийхээс өмнө үнэлгээний багийн гишүүд өөрсдөө болон үнэлгээ хийх гэж буй байгууллагуудын хооронд одоо байгаа болон урьд өмнө нь байсан аливаа холбоо харилцааг авч үзэх үүрэгтэй. Үнэлгээний багийн гишүүд хуваарилагдсан үнэлгээнд хоёр жилийн өмнөөс энэ үйл ажиллагаанд оролцоогүй байна.

6.6.2 MNAS нь үнэлгээний мэргэжилтэн/шинжээчдээс итгэмжлэлийн үнэлгээг бодит нотолгоонд үндэслэн шударгаар явуулах, үнэлэх боломжийг бүрдүүлэх, дарамт шахалт үзүүлсэн ч бодитой дүгнэлтийг гаргахыг шаардана.

6.6.3 Ерөнхий зарчмын хувьд MNAS-ийн үйлчлүүлэгчдээс ямар ч бэлэг хүлээн авахгүй. Хоолны урилгыг хүлээж авах нь анхаарал татахуйц асуудал байж болно. Тохирлын үнэлгээний байгууллагаас үдийн цайгаар хангах нь зөвшөөрөгдсөн цаг хугацаа, зардал багатай бизнесийн практик юм.

6.7 Хорооны гишүүд

6.7.1 MNAS-ийн итгэмжлэлийн үйл явцын найдвартай байдал нь Техникийн хороодын техникийн мэдлэгтэй холбоотой байдаг. Техникийн хороод зөвхөн техникийн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргадаг.

6.7.2 MNAS-ийн дарга нь техникийн хорооноос зөвхөн зохих техникийн мэдлэгтэй байх, ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчилгүй байх, тэдний гаргасан зөвлөмжүүд нь өөрөө өөртөө үйлчилдэггүй байх нөхцлийг хангах үүрэгтэй.

6.7.3 Техникийн хорооны гишүүнээр томилогдсоны дараа MNAS P 402 F01-ийн дагуу Шударга байдал, нууцлалын мэдэгдэлд гарын үсэг зурна.

6.7.4 ТХ-ны гишүүдийг MNAS-ийн дарга шийдвэр гаргах журамд сургах, шийдвэр гаргах явцад бодит байр суурьтай байх чадвараа харуулсны үндсэн дээр баталдаг. ТХ-ны гишүүдийн гүйцэтгэлийг 3 жилд нэг удаа хянана.

6.8 Хамаарал бүхий байгуулага

MNAS нь холбогдох байгууллагуудын жагсаалтыг жил бүр гаргаж, үүрэг даалгавар, Санхүүгийн эрсдлийн болон Аудитын баг, Дээд удирдлагуудад ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй эсэхийг тодорхойлно.

7 Хяналтын үйл ажиллагаа

7.1 MNAS нь шударга байдалд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийж, үнэлж, аюул заналхийлд дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

- Дотоод аудит;
- Удирдлагын дүн шинжилгээ;
- Санхүүгийн гадаад аудит;
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа; ба
- MNAS нь бүх оролцогч талуудад нээлттэй шударга байдал, гомдол, маргааны журмыг боловсруулна.

7.2 MNAS-ийн чанарын удирдлагын тогтолцоо, ISO/IEC 17011, ILAC/IAF-ийн заавал дагаж мөрдөх шаардлагыг тогтмол дагаж мөрдөж, бодлого, журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дотоод аудитыг хамгийн багадаа жилд 1 удаа зохион байгуулна.

7.3 Гадаад аудиторууд санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартад нийцэж байгаа эсэх, MNAS-ийн санхүүгийн байдал, гүйцэтгэлийг хараат бус, бодитой, үндэслэлтэй эсэхэд баталгаа өгнө.

7.4 MNAS-ийн үйлчлүүлэгчидтэй хийсэн санал асуулга нь үйлчилгээ үзүүлэх явцад тогтмол явагдана.

7.5 Шударга байдал, гомдол, маргааны журам (MNAS P 907 ба MASM BB 10-2017)-ын дагуу гомдлын системийн хувьд хараат бус, чадавхитай шинжээчид нь баталгаажсан гомдлыг шалгахаар томилогдоно. MNAS-ийн шийдвэрийн эсрэг гаргасан өргөдлийг Удирдах зөвлөлөөс баталсан Маргаан шийдвэрлэх комисс шалгана.

8 Холбогдох бүртгэл

- *MNAS P 602 F02. "Итгэмжлэлийн үйл явцад оролцогч талуудтай хийх гэрээ";*
- *MNAS P 401 F01 ба 403. "Шударга байдал, нууцлалыг хамгаалах гэрээ";*
- *MNAS P 403 F 01. "Эрсдэлийн үнэлгээний бүртгэл".*

---xxx---